

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2024.10.30

Есөнзүйл сум

ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/			Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
							2024 он				
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгр)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО											
3.1.Ес зүй, хариуцлагатай төрийн алба											
Зорилт 1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг	1	Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, давхардал, хийдлийг арилган, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	2021-2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-				Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийж сумын Засаг даргын захирамжаар 2, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 12 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг тус тус шинэчлэн баталж ажлын давхардал хийдлийг арилган ажиллаж байна.	100
	2	Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний	2021-2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-	Нийт төрийн албан хаагчдын			Төрийн албан хаагчдын 2024 онд нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын хувьд 2024 оны 11 сарын байдлаар нийт давхардсан тоогоор 20	100

төлөвшүүлнэ.		нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, тэднийг дотоод, гадаадын сургалт, давтан сургалтад хамруулна.				20-оос доошгүй хувь хамрагдсан байна			албан хаагчид 9,428,000 төгрөгний томилт хагас жилийн үр дүнгийн урамшуулал 2 албан хаагчид 13,737,000 төгрөгний урамшууллыг өгөн ажиллаж байна. Мөн Тамгын газрын 1 албан хаагчид зөөврийн компьютерээр ханган ажиллаж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 1 албан хаагчид 1,757,000 төгрөгний үр дүнгийн урамшуулал, 8 албан хаагчид 2,294,000 төгрөгний албан томилолтыг олгон ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид нь хуваарьт болон хуваарьт бус сургалтуудад цахим болон танхимаар суралцаж мэргэжил боловсролоо тогтмол дээшлүүлж байна. Мөн сургуульд шинээр ирж ажиллаж буй 5 багшийг сумын 8 айлын орон сууцанд байрлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байранд бага хэмжээний засвар хийсэн. Мөн 2 багшийг сумын төрийн албан хаагчдийн орон сууцанд байрлуулсан. 2024 оны тус байгууллага нь 2,100,000 төгрөгний томилолтыг олгоод байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэн ажиллах талаар онцгой анхаарч мэргэжлийн 1 багш, цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн боловсон хүчнээр 100% хангадсан нэмж 2 орон тоо батлуулан ажилтан нэмж авч нийт 16 орон тооны норматив дээр 15 албан хаагч ажиллаж байна. цаашид орон тооны бэлэн байдлыг хангах төрийн албаны залгамж холбоог сайжруулах зорилгоор 2 туслах багш бүлгийн багшаар суралцах саналаа боловсролын газарт хүргүүлэн хүний нөөц бэлтгэх тал дээр анхааран ажиллаж байна. Соёлын төвийн хувьд Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	
--------------	--	--	--	--	--	--------------------------------------	--	--	---	--

									хүрээнд байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд амаржсан 2 ээж, шинээр гэр барьж хурим хийсэн 1 албан хаагчид мөнгөн тэтгэмж олгосон. Мөн чадахуйн зарчимын хүрээнд Соёлын өвийн ажилтныг чадавхжуулан ажиллуулж байна. 5 албан хаагчийг салбарын сургалтад танхимаар болон цахимаар хамруулж 540000 төгрөгийн томилолтын зардлыг олгоод байна. Манай байгууллагын ажилчид 100 хувь гэр бүлтэй сум орон нутагтаа амьдардаг цаашид тогтвор сууршилтай ажиллах боловсон хүчинтэй. Бүжгийн болон хөгжмийн багшийг мэргэшүүлэх танхимын сургалтанд сургах шаардлагатай байна.	
3	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.	2021-2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-	Ажлын гүйцэтгэл, үр дүн		Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж хагас бүтэн жилээр биелэлтийг нь тооцон мэдээллийн сан үүсгэж архивт шилжүүлэн ажиллаж зохих урамшууллыг хуул дүрэм журмын дагуу олгож ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үр дүнг гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлдэг тогтолцоо бий болсноос хойш 2022 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр тус сургуулийн 7 багш, 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 багш, 2024 онд 3 багш 25-100 хүртэлх цалингийн урамшууллыг улирал бүр авах нөхцөл бүрдсэн бөгөөд үйлчилгээний ажилчид сургуулийн захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, үйл ажиллагааны гүйцэтгэлийн дүнгээр улирал бүр уламшуулал олгож байна. 2024 оны хагас жилийн байдлаар Боловсрол шинжлэх ухааны газартай байгуулсан гэрээний	100	

									<p>биелэлтийг тооцуулан ажилласан. Байгууллага болон багшийн үнэлгээг БШУСайдын 2022 оны “Журам батлах тухай” А/ 430 тоот тушаалыг баримтлан жилд нэг удаа үнэлгээг хугацаанд нь ажлын хэсэг гарган үнэлсэн. Гүйцэтгэлийн үнэлгээнд 3 багш хамрагдсан бөгөөд 1 багш улирал бүр урамшуулал олгож байна. Байгууллага дээрх Ёс зүйн дэд хороог байгуулан төлөвлөгөө боловсруулан албан хаагчдыг мэдээ мэдээллээр хангах Ёс зүйн талаар алдаа гаргахгүй тал дээр зөвлөгөө сургалт мэдээлэл өгөх урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулан ажилласан. Дээрх хугацаанд ажлын хариуцлага алдаж ганцаарчлан сануулж уучлалт гуйсан 1 хүсэлт бичсэн 1 зөрчил илэрсэн.</p>	
4	<p>Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно.</p>	2021-2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-	Төрийн захиргааны байгууллагын 50 хувьд хүргэнэ.		<p>Төрийн байгууллагууд иргэдийн санал асуулга өргөдөл гомдолыг хүлээж авах цахим хаяг болон суурин утсыг тогтмол ажиллуулж үйл ажиллагаандаа иргэдийн санал гомдлыг хэлэлцэн хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн албан байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан үр дүнг өөрсдийн цахим хуудсаараа иргэдэд ил тод нээлттэй тогтмол хүргэж байна. Төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын сул орон тоо гармагц төрийн албаны салбар зөвлөлд журмын дагуу захиалгыг хүргүүлэн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллалаа. Одоогийн байдлаар зөрчилтэй томилгоотой албан хаагч байхгүй байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны талаар удирдах дээд шатны байгууллагат мэдэгдэх, гарсан орон тоон</p>	100	

										дээр нээлттэй сонгон шалгаруулалтыг 2 удаа зарлан нийт 9 хүний ажилд орох тухай өргөдлийг хүлээн авч холбогдох хууль дүрмийн дагуу 2 ажилтан бүр орон тоон дээр сонгон шалгаруулж авсан. Одоогийн байдлаар зөрчилтэй томилгоотой албан хаагч байхгүй байна манайх байгууллагат 2024 онд 19 төрлийн өргөдөл санал ирснээс ажилд орохыг хүссэн 9, чөлөө хүссэн 8, ур чадварын нэмэгдэл олгохыг хүссэн 1, бусад 1 гэсэн агуулгатай байна дээрх өргөдлийн цаг тухай бүр шийдвэрлэсэн. 2 хүнийг бүр ажлын байранд авч, 8 хүнд чөлөө олгосон бол, ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу олгох талаар тайлбарлан 3 сайдын хамтарсан тушаалтай танилцуулсан. Энэ талаар ямар нэгэн гомдол санал гараагүй байна. Соёлын байгууллагын хувьд Иргэдийн санал асуулга өргөдөл гомдлыг хүлээж авах цахим хаяг болон утасны дугаарыг тогтмол ажиллуулж, санал гомдол хүлээн авч ажиллаж байна. Мөн байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан үр дүнг өөрсдийн цахим хуудсаараа иргэдэд ил тод нээлттэй тогтмол хүргэж байна. Ажлын байрны сул орон тоо гармагц төрийн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, шалгалт аван хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар зөрчилтэй томилгоотой албан хаагч байхгүй өөрийн хүсэлтээр ажлаас гарах-2, жирэмсний амралт авах-1, ажилд орох-2 өргөдөл ирснийг зохих хууль журмын дагуу шийдвэрлээд байна	
	5	Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн	2021-2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-	Зөрчилтэй шийдвэрийг			Жил болгон тухайн сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг шинэчлэгдэн гарч буй	100

		албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.						н тоог 70 хувиар бууруулна.		хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөн Өвөрхангай аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст хянуулан ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар сумын 4 багийн 24 өрхийн А данс, Засаг даргын үйл ажиллагааны чиглэлээр гарсан 131 захирамж, боловсон хүчний чиглэлээр гарсан 21 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллагааны чиглэлээр гарсан 6 тушаал, боловсон хүчний чиглэлээр гарсан 18 тушаалыг тус тус цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаад байна. Захирамж тушаал гарах тухайн цаг бүрт үндэслэл хэсэг дэх хууль, тогтоол, дүрэм журмыг албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамын дагуу хянах үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Соёлын төвийн хувьд 2024оны 11 сарын байдлаар байгууллагын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн 3 албан хаагч нарт үр дүнгийн урамшуулалыг олгоод байна. Монгол улсын соёлын сайдын 2023 оны 10дугаар сарын 09-ны өдрийн А390 дүгээр тушаалыг үндэслэн 2023 онд ажилласан 6 албан хаагчид үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн урамшуулал, Соёл урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд уралдаан зарлаж 1,2,3дугаар байр эзлүүлэн цалингийн 25%, 20%, 15%-аар тус тус шагнасан. Ёсзүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	
Бүлгийн дүн										100%	
3.2.Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээ											
Зорилго Төрийн	1.	1	3.2.1.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн	2020 -	ЗДТГ	120,0	19 оpe	Call cente		Засаг даргын Тамгын газрын хувьд "CALL center" үйлчилгээ буюу түргэн шуурхай	90

байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлэн, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.	төвд “Call center” үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээг сумдад бий болгон, төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх үйл ажиллагаа явуулна.	2024	дарга	сая Улс, орон нутгий н төсөв	рат ор	г байгу улж, цахим үйлчи лгээг нэмэг дүүл нэ.		утасны үйлчилгээг нэвтрүүлэн иргэдийн өргөдөл гомдол санал асуулга болон утсаар өгж болох үйлчилгээг цаг тухай бүрт нь өгж ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар emongolia цахим системээс нийт 285 иргэнд, emongolia операторийн үйлчилгээг үзүүлсэнээс 274 лавлагаа, олон шатлалт 11 үйлчилгээг үзүүлээд байна. Мөн 50 гаруй иргэнд шүүхийн талаарх мэдээ мэдээлэл хүргэж 80 гаруй иргэнд хууль эрх зүйн зөвлөгөөг хүргэж ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 15 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 2000 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Гэрэгэ Киоск машины үйлчилгээг нийтиргэнд хүргэн ажилласан байна.	
2	Төрийн албаны сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, үйл ажиллагааг нь ил тод болгоход шаардлагатай техник хэрэгслээр хангаж, төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанарыг сайжруулан, мэдээлэл технологийн ажилтныг чадавхижуулна.	2020 - 2024	ЗДТГ дарга	Улс, орон нутгий н төсөв	-	Цахи м шилж илт, тоног төхөө рөмж ийн шинэ члэлт		Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангах үүднээс Засаг даргын Тамгын газрын интернетийн хурдыг 20 gb-ийн хурдаар авч сард 229900 төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангах үүднээс цэцэрлэгийн интернэтийн холболтыг хийж, багш нарын дата багцтай холбон нийт 1115000 төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна. Соёлын төв нь 2022 онд байгууллагын интернетын хурдыг сайжруулж улсын төсвийн 2 сая төгрөгөөр МИКОМ-Интернетын төхөөрмж тавиуллаа.	100
7	Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа	2020 -	ЗДТГ	360,0 сая	Ил Тод	Төсө вт		Есөнзүйл сум ЗДТгазар, Зар есөнзүйл сум гэсэн цахим хаягуудаар төрийн	100

		сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлнэ.	2024	дарга	төгрөг Улс, орон нутгийн төсөв	байдлын үзүүлэлт	тусгах, ил тод мэдээлж хэвших			байгууллагын болон албан хаагчид мэдээ мэдээлэл болон хийсэн ажлын тайланг иргэдэд шуурхай хүргэн ажиллаж байна. Сумын хэмжээнд иргэдэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэх үүднээс ЕСӨНЗҮЙЛ сэтгүүлийг сумын Засаг даргын Тамгын газраас бэлтгэн гаргаж мэдээллийн хүртэмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн сумын хэмжээнд Иргэний танхим, Нэг цонхны үйлчилгээгээр иргэдэд тогтмол үйлчилж мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.	
Бүлгийн дүн										96,6%	
3.3.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал											
Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.	1	3.3.1.1. Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2024	ХЭЗХ	10,0 сая Орон нутгийн төсөв	22000 хүн хамрагдсан (20 20)	3000 хүнд эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна			Мэргэжилтэн нь Emongolia цахим систем болон иргэдэд шууд хүрч үйлчлэх нийт 95 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Үүнд: 1. Имонголиа цахим системээс лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт зэрэг нийт 348 цахим үйлчилгээ 2. Албан байгууллага болон иргэдэд үзүүлэх хуулийн зөвлөгөө 3. Иргэдэд хүрч үйлчлэх эрх зүйн булан 4. Албан байгууллага иргэдэд хүрч үйлчлэх сургалт сурталчилгаа 5. Иргэдэд хүрч үйлчлэх шүүхийн туслалцаа мэдээллээр хангах 6. Иргэдэд Киоск машины үйлчилгээг үзүүлж лавлагаа мэдээллийн сангийн төлбөрийн үйлчилгээг цаг алдалгүй хурдан шуурхай төлөх 7. Иргэдэд ГХУС ажлын талаарх мэдээ мэдээлэл зэрэг нийт 95	90

									<p>үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>2024 оны 11 дүгээр сарын байдлаар emongolia цахим системээс нийт 285 иргэнд, emongolia операторийн үйлчилгээг үзүүлсэнээс 274 лавлагаа, олон шатлалт 11 үйлчилгээг үзүүлээд байна. Мөн 50 гаруй иргэнд шүүхийн талаарх мэдээ мэдээлэл хүргэж 80 гаруй иргэнд хууль эрх зүйн зөвлөгөөг хүргэж ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 15 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 2000 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Гэрэгэ Киоск машины үйлчилгээг нийтиргэнд хүргэн ажилласан байна.</p>	
3	Монгол Улсын хууль, тогтоомж, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн аймгийн нэгдсэн санг шинэчлэн, кодификаци хийнэ.	2021 - 2024	ХЭЗХ	Орон нутгийн төсөв	479 хууль эрх зүйн акт аар лавлаг аа, мэдээллийн сан баяжуулсан (20	Шинэ батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль, эрх зүйн актаар баяжилт хийсэн байна.		<p>2021-2024 оны байдлаар нийт хууль тогтоомжийн бүртгэлийн санд нийт 1258 актаар сангаа баяжуулж одоогоор хууль тогтоомжийн бүртгэлийн лавламжийн санд 7376 эрх зүйн акт байна. Мөн 2021-2024 оны 3 дугаар улирлын байдлаар 4 жилийн хугацаанд нийт 555 зүйл заалтаар өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн байна. Шинээр гарсан хууль тогтоомжууд, тогтоол шийдвэрүүд болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийг бүртгэл хяналтанд авч хувийн хэрэгжүүлж холбогдох албан тушаалтанд танилцуулж ажиллаж байна. Холбогдох дээд байгууллага болон бусад байгууллагаас ирсэн хугацаатай болон хариутай бичгүүдийг тухайн цаг хугацаанд нь хариуг нь хүргүүлж ажиллаж байна. Төсвийн байгууллагын бичиг хэрэг, тушаал</p>	100	

						20)				шийдвэрүүдэд хяналт тавин ажиллаж байна.	
	7	Орон нутаг дахь жөндөрийн тэгш байдлыг хангах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагууд, олон нийтэд жөндөрийн боловсрол олгоно.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	12,0 сая	58 байгууллагад хүрч үйлчилсэн (20 20)	78 байгууллагад хүрч үйлчлэх			Суманд жөндөрийн тэгш байдлыг бүхий л салбарт тэгш байлгах аар чиглэн ажиллаж байна. Албан байгууллага аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалт хийх ажлын хүрээнд жөндөрийн талаарх боршур гарын авлага болон байгууллагуулын хүйсийн тэгш харилцаа болон жөндөрийн оролцоо талаар харилцан ярилцлага хийж ажилласан байна. Сум хөгжүүлэх сангаас зээл хүссэн 2 залуу гэр бүлд 9 сая төгрөгний зээл олгож үйл ажиллагааг нь дэмжиж ажиллалаа. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн талаарх мэдээллийг сумын фейсбүүк группээр иргэдэд нээлттэй мэдээлсэн. Аймгийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа түүгээр явагдах сургалтын зар мэдээг иргэдэд түгээж ажилласан. 2022 онд нийтийг хамарсан ажилд 17 эмэгтэйг зуучилж түр ажлын байраар хангасан. Мөн төмс хүнсний ногоо тариалах бүлийн төсөлд 8 эмэгтэй хамрагдаад байна. 2023 оны хувьд Малжуулах хөтөлбөрт 2 эмэгтэй, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлийн төсөлд 2 эмэгтэй хамрагдаж ажлын байртай болсон. Мөн албан газар, аж ахуйн нэгж байгууллагад 8 эмэгтэй ажилд зуучлагдан орсон. Мод тарих болон нийтийг хамарсан ажилд 10 эмэгтэй, ямаа самнах ажилд 4 эмэгтэй хамрагдаж түр ажлын байраар хангагдан өрхийн орлогоо нэмэгдүүлж ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрт 1 иргэн хамрагдан ажлын байртай болсон.	90

Зорилт 3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.	1	“Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Цагда агийн хэсэг	Орон нутгийн төсөв	Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлсэн.	Хөтөлбөрийг 50-аас дээш хувьтай хэрэгжүүлсэн байна.		Амартайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагуудад хяналт тавьж, өдөр оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа тогтмол шалгаж архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт Олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа согтууруулах ундаа хэрэглэсэн нийт 13 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч анхааруулага хүргэн ажилласан байна. Мөн 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавьж. Сумын гудамж, талбайд өдөр, шөнө тодорхой цагуудад олон нийтийн эргүүлийн хамт хяналт шалгалтыг хийж ажиллаж, нийтийн хэв журам зөрчих, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах явдлаас урьдчилан сэргийлж ажиллаж байна. Мөн улсын төлөвлөгөөт ажил болон бусад нийтээр дагаж мөрдөх өдрүүдэд сумын Засаг даргын захирамжаар Согтууруулах ундаа худалдаалдаг аж ахуй нэгжүүдэд тооллого явуулан хориглох арга хэмжээг цаг тухай бүрт нь авч ажиллаж байна.	90
	2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон	2021 - 2023	Цагда агийн хэсэг	60,0 сая Орон нутгийн төсөв	Арвайхээр 138 хяналтын кам	Хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажил		Есөнзүйл сумын цагдаагийн хэсгийн алба хаагчид Гэмт хэргээс урьдчилна сэргийлэх чиглэлээр Засаг даргын Тамгийн газар болон Иргэдийн хуралтай хамтран ГХУС-чиглэлээр Сумын зар групп болон Интернет орчинд санамж сэрэмжүүлэг тарааж сумын иргэдэд заавар зөвлөгөө өгч ажилласан. Нийтийн хэв журам	100

		нийтийн оролцоог нэмэгдүүлэн, аймаг, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ.				ер ашиглаж байна	луулсан байна			хамгаалах чиглэлээр хариуцсан сумандаа өдөр,орой эргүүлийн 12 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Сумын хэмжээнд нийт 137 камер байршуулан ашиглаж байгаагаас шинээр 2022-2023 онд 55 камер суурилуулсан байна. Сумын хэмжээнд Камержуулалт-3, Камержуулалт-4, зэрэг арга хэмжээг жил болгон сумандаа чанартай зохион байгуулан сумын Төрийн байгууллагууд болон үйл ажиллагаа эрхэлдэг Аж ахуй нэгжүүдтэй хамтран амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.Сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021- онд 5, 2022 онд 2, 2023 онд 2 нийт 9 цамхагт гэрлийг суурилуулан цагийн релэн тохируулан ажиллаж байна. 2024 оны хувьд Цагдаагийн хэсэг болон аж ахуй нэгжийн нийт 5 камер шинээр авч ажиллжуулж байна. Мөн энэ онд сумын төвийн болон нийтийн эзэмшлийн газар байрлалтай камеруудад засварын ажлыг зоххион байгуулж чанарыг сайжруулан ажиллаж байна.	
	4	Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Цагдаагийн хэсэг	12,0 сая Орон нутгийн төсөв	.	Зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх		Есөнзүйл сумын цагдаагийн хэсгийн алба хаагчид архидан согтуурдаг хүмүүсийг зөрчлийн тухай хуулиар архидан согтуурсан айл гэрийн амгалан тайван байдлыг алдагдуулсан дуудлага мэдээлэл 2022 онд 18 бүргэгдсэн. Үүнээс 17 дуудлага мэдээлэлд арга хэмжээ тооцож ажиллалаа. 2023 оны хувьд 5 дуудлага бүртгэгдсэнээс 5 дуудлагад Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дэх зүйл заалтын дагуу арга хэмжээ авч ажилласан. Зам тээврийн осол гэмтэл байдлаар Есөнзүйл суманд 2022 онд 5, 2023 оны 10 сарын байдлаар 2 бүртгэгдэж	100	

									<p>арга хэмжээг авч ажилласан. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын адргын баталсан магестрал замд хяналт шалгалтыг цагийн хуваарийн дагуу тогтмол хийж, Хурд, Гэрэл сумын гарцанд дээр буюу Улсын А/301 магстрал зам 7 хонгийн 3 хугацаанд цагийн менежментийн үүрэг гүйцэтгэж 2022 онд 443 жолоочид 13.269.000 мөнгө бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч, 2023 онд 332 жолоочид 10,858,500 мөнгө бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч Жолооч нарт хурд тохируулж явах, хамгаалах бүс тогтмол зүүх дээр санамж сэрэмжүүлэг 500 ш боршуур тараан ажиллаж байна. Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажил арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллах болно.Гэр бүлийн хүчирийлэл 2 айл бүртгэгдсэн байгаа Одоогоох сумын хамтрсан багтай кэйс нээн ажиллаж байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд нийт Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 7 хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс 1 хэрэг шийдвэрлэх шатандаа 6 хэрэг Шүүхийн шийдвэрээр торгуулийн арга хэмжээ авагдан шийдвэрлэгдээд байна. Мөн 2 сарын хугацаанд 50 гаруй удаа улсын чанартай авто зам дагуу постонд үүрэг гүйцэтгэн нийт 13,000,000 гаруй торгуулийг төвлөрүүлээд хүү торгуулийн орлогийг 70 гаран хувьтай биелүүлээд байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

	5	Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг эрс бууруулна.	2021 - 2024	Цагдаагийн хэсэг	80,0 сая Орон нутгийн төсөв	Орон нутгаас төсөв шийдвэрлэн хяналт шийдвэрлэлт	Хяналт, шийдвэрлэлт, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, малчид нөхөрлөлийг урамшуулах		Есөнзүйл сумын Цагдаагийн хэсгийн алба хаагчид Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Есөнзүйл сумын Иргэдийн хуралтай хамтран Малчидын эргүүл гаргаж, Мөн Улаанбаатар хотруу мал хийж яваа иргэдийн гарал үүсэлийн бичиг баримтыг шалгана. Мал эмнэлэгийн байцаагч Даваасүрэнтэй хамтран ажиллаж байна. Тус сумын Түүхий эд авдаг сумын Ченж нарын авч буй мал махын бүртгэл судалгаа нээн ажиллалаа. Мөн 2022 оны байдлаар мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. Харин 2 айлын 6 тооны адуу алдагдсан мэдээлэл гомдолоор бүртгэгдсэн бол 2023 малын хулгайн гэмт хэрэг болон мал алдагдсан бүртгэл бүртгэгдээгүй байна. 2024 оны хувьд 1 малын хулгай бүртгэгдэн шийдвэрлэх шатандаа явж байна. Сумын хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн дрограммаас нийт 823 малын гарал үүслийн зөвшөөрлийн бичгийг иргэдэд олгон хяналтыг тавин ажиллаж байна.	90
Зорилт 4. Хууль сахиулах болон зарим хяналтын байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	1	Аймгийн “Төрийн Архив”-ыг зориулалтын байртай болгож, орон тооны болон гэрээт ажилтанг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулна.	2021 - 2024	ХЭЗХ, Архив бичиг хэргийн эрхлэгч	2,5 тэрбум Улс, орон нутгийн төсөв	Зориулалтын байргүй, орон тоо 5 ажилтнууд дутуу (20 20)	Архивын байрны ТЭЗҮ-г боловсруулан, төсөвт тусгуулна		Архив бичиг хэргийн эрхлэгчийн ажлыг хөнгөвчлөх баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх тал дээр түлхүү анхаар EPSON DS-530 маркийн хурдан скайнараар хангаад байна. 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар сумын 4 багийн 24 өрхийн А данс, Засаг даргын үйл ажиллагааны чиглэлээр гарсан 131 захирамж, боловсон хүчний чиглэлээр гарсан 21 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллагааны чиглэлээр гарсан 6 тушаал, боловсон хүчний чиглэлээр гарсан 18 тушаалыг тус тус цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаад байна.	100

	9	Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлэн, ажиллах нөхцөлийг сайжруулж, хувцас, тусгай хэрэгслийн хангалтад дэмжлэг үзүүлж ажиллана.	2021 - 2024	ЗДТГ дарга	800,0 сая Орон нутгийн төсөв	Аймгийн хэмжээнд 15 олон нийтийн цагдаа ажиллаж байна.	Олон нийтийн цагдаагийн орон тоо нэмэгдүүлж, хувцас хэрэглээр хангах			Есөнзүйл суманд 2019 оноос эхлэн Олон нийтийн цагдаагийн орон тоог бий болгон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 онд Олон нийтийн цагдаагийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн нормын хувцас хэрэгсэлээр хангаж 500000 төгрөгийн цалинжуулан ажиллаж байсан. 2023 оноос Олон нийтийн цагдаагийн орон тоонд ажиллаж буй албан хаагч байхгүй байна.	50
Бүлгийн дүн										90%	
3.5.Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх											
Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3	Аймгийн дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангана.	2021 - 2024	ЗДТГ дарга	Орон нутгийн төсөв	-	Хугацаанд төлөвлөгөө, даалгаврыг боловсруулан батлуулна.			Есөнзүйл сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг аймаг, сумын Засаг даргаар баталгаажуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Суманд маш нууц, нууцын зэрэглэлтэй 24 албан бичгийг төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хүрээнд хадгалж, биелэлтийг нь ханган ажиллаж байна. Сумын дайчилгааны төлөвлөгөөг хийж хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.	90

	4	Ерөнхий боловсролын бүх сургуулиудад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, сумдад цэрэг-эх орны сэдэвт хөшөө, дурсгалын зүйл, бодит түүхийн ой санамжийг сэргээх, илэрхийлэх санал санаачилгуудыг дэмжиж ажиллана.	2021 - 2024	ЕБС, ЗДТГ дарга	Орон нутгий н төсөв	-	ЕБ-ын сургуул ийн 1 буюу түүнэ эс дээш хичээ лийн танхи мыг байгу улж, тохи жуул на.		Өвөрхангай аймагт жил бүр зохион байгуулагддаг Цэрэгжилтийн дел тэмцээнд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11-10 дугаар ангийн 13 хүүхдийн жагсаал, гардан гэсэн үзүүлэх тоглолтыг бэлтгэн 2024 оны 2-р улиралд тэмцээнд оролцож 2-р байранд орсон амжилттай байна. Тус тэмцээний ирж очих унаа болон хоолны зардалд Засаг даргын тамгын газраас 800000 төгрөгийн зардал гараад байна. 2024 оны хувьд цэрэг эх оронч үзлийг суулгах төлөвшүүлэх уралдаан тэмцээн зохион байгуулагдаагүй байна.	90
Зорилт 2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ.	2	Сумдад гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрөл бүрээр эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.	2021 - 2024	ЗДТГ дарга	160,0 сая Орон нутгий н төсөв	Гамшг ийн эрсдэл ийн тойм судалг ааг 13 сум анд хий сэн.	нэг сума нд судал гаа хийлг эх		Сумын хэмжээнд 2021 онд гамшгын эрсдэлийн үнэлгээг хийн түүнд тулгуурлан ковид цар тахлын үед урьдчилан сэргийлж төлөвлөгөөг боловсруулан ажилласан. Сумын гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах үнэлгээг хийлгэхээр үнэлгээний газартай хамтран ажиллаж байна. Аюулын төрөл бүрээр аймгийн Онцгой байдлын газартай хамтран сумын үнэлгээг гаргаад байна.	70
	4	Сумдын гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024	ЗДТГ дарга	100,0 сая Орон нутгий н төсөв	-	Гамш гаас хамга алах иж бүрэн сурга лтыг зохио н байгу		Сумын Засаг даргын 2024 оны 04-р сарын 02-ний өдрийн А/38 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж сургалт сурталчилгаа, гамшиг эрсдлийн үед хэрхэн ажиллах талаар дадлага сургуулалтыг 1 удаа хийгээд байна. Сумын гамшгаас хамгаалах 2024 онд	100

							улна.			<p>төлөвлөгөөнд 1 удаа тодотгол хийж ажилласан. Суманд 2024 оны 2-р улиралд “Команд штаб”-ын сургуулалтыг амьжилттай зохион байгуулж дүүрэн хангалттай үнэлгээ авсан үзүүлэлттэй байна. 2023 онд Дадлага сургуулалтын ажлын хүрээнд 9,860,000 төгрөгөөр мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний 68 албан хаагчдад дүрэмт хувцас авч өгөн малгай, гитл, өмдөөр жигдлэх ажил хийгдээд байна. Мөн мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн өөрсдөө 40,000 төгрөг гарган хүн нэг бүр хувийн аранзтай болж бэлтгэл бэлэн байдал хангагдаад байна. Улсын хэмжээнп гамшгаас хамгаалах өдрийн хүрээнд Мөнхбулаг 1,2,3,4,5,6 командыг өгөн ард иргэд мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд дадлага сургуулалтыг амжилттай хийсэн.</p>	
5	<p>Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.</p>	<p>2021 - 2024</p>	<p>ИТХ нарийн бичиг дарга</p>	<p>Олон улсын байгууллага</p>	-	<p>Хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.</p>		<p>2022 онд Мөнхбулагын 2, Эрээний 4 дүгээр багаас сонгогдсон төлөөлөгчид сайн дурын аян өрнүүлж сумаас өөр аймаг, сумын нутагт оторлож байсан 6 өрх тус бүрт 0,5 тонн нүүрс, хүнсний болон эмний багц нийт 150000 төгрөгийн тусламж хүргэсэн. Сумын Ерөнхий Боловсролын сургуулийн хими биологийн багш Д.Баасанжаргал өөрийн удирдсан ангийн сурагчдыг “Өсвөрийн улаан загалмай”-н бүлэг байгуулан гишүүнээр элсүүлж байнгын хэвтэрийн харж хандах хүнгүй 2 өндөр настанд 2 портёр машин аргал түүж, малчдад хурга, ишигний нэмнээ 30 ширхэг, хурга, ишигний уут 30 ширхэг, бээлий 30 ширхэгийг хийж малчдад мал төллөх үеэр гардуулан өгч дэмжлэг үзүүлсэн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон төлөөлөгчдийн зүгээс санаачлан Албан</p>	90		

									байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 120 өрхийн хүүхдүүдэд “Эх үрсийн баяр”-ыг тохиолдцуулан бэлэг өгч бяцхан зүрхнүүдийг баярлуулсан. Сумын Улаан Загламайн нийгэмлэгийн салбар хороо 2022 оны эхний 9 сарын байдлаар 900000 төгрөгний татварт оруулж нигүүлсэнгүй үйлсэд хамтран ажиллаж байна. Сумын анхан шатны Улаан загалмайн хорооноос сумын гамшгаас хамгаалах штабтай хамтран гамшгийн үед ард иргэдийн амь насыг гамшгаас хамгаалах, ослоос урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл тохиолдсон үед нөхөн сэргээх ажлыг хурдан хугацаанд зохион байгуулах, гамшгийн үед иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, хариу арга хэмжээ авах талаар сургалтуудыг зохион байгуулж ажилласан. Мөн 2023 онд улаан загалмайн холбооноос сумын үер усны гамшигт үзэгдэлд өртөж гэрээ урсгасан болон мал нь үрэгдсэн 2 өрхөд өрх тус бүрд 370,000 төгрөгний мөнгөн тусламж, гал тогооны ком хэрэгсэл, 4 хөнжил, 4 гудасны ахуйн тусламжийг үзүүлээд байна. Сумын Улаан Загламайн нийгэмлэгийн салбар хороо 2024 оны эхний 11 сарын байдлаар 934000 төгрөгний татварт оруулж нигүүлсэнгүй үйлсэд хамтран ажиллаж байна.	
Бүлгийн дүн									88%	
Нийт дундаж									92,6%	

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ